


“БЭРС ФИНАНС ББСБ” ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 01-р сарын  
04-ний өдрийн 23/01а/01 тоот тогтоолын Хавсралт 11”

**“БЭРС ФИНАНС ББСБ” ХХК-ИЙН**

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭХ ЖУРАМ**



**Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Энэхүү журмын зорилго нь “Бэрс финанс ББСБ” ХХК (цаашид “компани” гэх)-ийн хувьцаа эзэмшигчид болон бусад хөронгө оруулагчидтай хамтран ажиллах, тэд нарт мэдээлэл хүргэх чиглэл, зарчмыг тогтооход оршино.

**Хоёр. Хувьцаа эзэмшигч, хөронгө оруулагчдад хүргэх мэдээллийн төрөл**

- 2.1 Компани нь Компанийн тухай хуульд заасны дагуу дараах баримт бичгийг хадгалж, хууль болон компанийн дүрэм, журмаар тогтоосон эрх бүхий этгээд болон хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчдын шаардлагаар танилцуулах үүрэгтэй:
- 2.1.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр;
  - 2.1.2 Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт;
  - 2.1.3 Төрийн эрх бүхий хяналт зохицуулалтын байгууллагад хүргүүлсэн мэдээ, тайлан.
  - 2.1.4 Компанийн үйл ажиллагааг зохицуулах бүхий л дүрэм журмууд
  - 2.1.5 Компанийн үйл ажиллагаатай холбогдох бусад баримт материалууд
  - 2.1.6 Нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт бичиг;

**Гурав. Хувьцаа эзэмшигчид мэдээлэл хүргэх**

- 3.1 Компанийн үйл ажиллагааны талаар мэдээлэл авахыг хүссэн хувьцаа зэмшигч нь ТУЗ-ийн нарийн бичгийн даргад хүсэлтээ хүргүүлнэ.
- 3.2 Энэ журмын 2.2-т заасан хүсэлтэд ямар мэдээллийг, ямар хэлбэрээр, хэдийд авах хүсэлтэй байгаагаа заасан байна.
- 3.3 Хувьцаа эзэмшигчийн хүсэлтийг хүлээн авсан ТУЗ-ийн нарийн бичгийн дарга уг мэдээллийг хариуцан толилуулах боломжтой ажилтанд мэдээллийг хувьцаа эзэмшигчдийн хүссэн хэлбэрээр, хүссэн хугацаанд нь гаргаж өгөхийг үүрэг болгоод биелэлтэд нь хяналт тавина.
- 3.4 Хувьцаа эзэмшигчдийн хурлын өмнө хувьцаа эзэмшигчдэд дараах мэдээллийг хүргүүлнэ. Үүнд:
- 3.4.1 Компанийн үйл ажиллагааны жилийн тайлан /Компанийн үйл ажиллагааны ил тод байдлын журмын Гуравдугаар хэсэгт заасан мэдээллийг агуулсан/;

- 3.4.2 Жилийн санхүүгийн тайлан холбогдох тайлбар, тодруулга, аудитын байгууллагын дүгнэлтийн хамт;
- 3.4.3 Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр, хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн бол үндэслэл;
- 3.4.4 Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдийн тухай танилцуулга;
- 3.4.5 Тайлангийн жилд хийсэн сонирхлын зорчилтэй хэлцлийн жагсаалт, эдгээр хэлцлийг Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан журмын дагуу хийсэн эсэх тухай аудиторын дүгнэлт;
- 3.4.6 Компанийн болон хяналтын багц хувьцаа эзэмшигчдийн нэгдмэл сонирхолтой этгээдийн тухай мэдээлэл /хэрэв тэдгээр нь компанийн хувьцааг эзэмшдэг бол/;
- 3.4.7 Компанийн ТУЗ-ийн гишүүд гүйцэтгэх удирдлагын зардал, цалин, урамшуулал;
- 3.4.8 Хэрвээ ээлжит хурлаар компанийн дүрэмд нэмэлт оөрчлөлт оруулах тухай асуудал хэлэлцэх бол нэмэлт, оөрчлөлт оруулах төсөл, үндэслэл, тайлбарын хамт;
- 3.4.9 Компанийг оөрчлон байгуулах асуудал хэлэлцэх бол оөрчлон байгуулах хэлбэр, үндэслэл, оөрчлон байгуулах журам, үүнтэй холбогдсон хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх журам зэргийг тусгасан оөрчлон байгуулах төсөл, бусад холбогдох баримт бичиг;
- 3.4.10 Нэмж хувьцаа гаргах асуудал хэлэлцэх бол түүний борлуултаас олсон орлогыг хэрхэн зарцуулах тухай танилцуулга, эдийн засгийн үр ашгийн тооцоо, хувьцаа эзэмшигчид хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхээ хэрэгжүүлэх журам;
- 3.4.11 Өрийн бичиг бусад үнэт цаас гаргах тухай асуудал хэлэлцэх бол бол түүний борлуулалтаас олсон орлогыг хэрхэн зарцуулах тухай танилцуулга, эдийн засгийн үр ашгийн тооцоо;
- 3.4.12 Компанийн засаглалын тайлан
- 3.4.13 ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагаанд өгсөн үнэлэлт дүгнэлт

3.5 Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах бусад асуудлыг хэлэлцэхэд хувьцаа эзэмшигчдэд ямар бичиг баримт танилцуулахыг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэрт заасан байна.